



НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Дотоод аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг, Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын ажлын жилийн эцсийн тайланг хорооны хурлаар хэлэлцэн "Бүрэн хангалттай" гэж үнэлсүгэй.

2. Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН